

БАТЛАВ.
"ТАВАН БОГД МЕНЕЖМЕНТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БАТБААТАР

БАТЛАВ.
САНГИЙН ЯАМ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАНҮҮРГИЙГ ХАРИУЦАГЧ
О.Ц.МАНДАГ / С.НАРАНЦОГТ /



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2018 оны 01-р
сарын 03-ны өдөр

№ 25/01 /...1.

Улаанбаатар хот

Нэг талаас "Таван Богд Менежмент" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх), түүнийг төлөөлж Борлуулалтын менежер Э.Бадмаараг нөгөө талаас "Сангийн Яам" ХХК (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж НБББГ-н дарга Г.Түвдэндорж нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг үндэслэн дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь ажил гүйцэтгэгч захиалагчийн гэрээнд заасан захиалгат ажлыг заасан чанарын дагуу, хугацаандаа хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх, захиалагч нь гэрээний дагуу захиалга өгөх, ажлын үр дүнг хүлээн авах, ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлж барагдуулахтай холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2 Тус гэрээнд үндэслэн үйлдсэн аливаа Гэрээ, Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Гүйцэтгэх ажил, ажлын чанар

- 2.1 Гүйцэтгэгч нь захиалагчаас өгсөн захиалгын дагуу ажлыг хавсралтанд тусгасан үнэ, чанар, тоо, хэмжээтэйгээр хэвлэж, тохирсон хугацаандаа хүлээлгэн өгнө.
- 2.2 Захиалагч нь Гэрээний 2.1-д зааснаас өөрөөр дахин захиалга өгөх тохиолдолд Гүйцэтгэгчтэй тухайн үед нь харилцан тохиролцож, захиалгын хуудас үйлдэх ба захиалгын хуудсанд үнэ, чанар, тоо, хэмжээг тодорхой зааж өгнө.
- 2.3 Доголдолтой бүтээгдэхүүн буюу доголдолтой захиалгат ажил гэдэгт дараах зүйлийг ойлгоно:
 - 2.3.1 Гэрээний 2.1, 2.3-д заасан чанар, үзүүлэлтийн дагуу ажлыг хэвлээгүй;
 - 2.3.2 Захиалагчийн баталгаажуулсан эх, текстийн формат, хэвлэлтийн өнгө зөрсөн, хавтасны наалт, бүрэлт доголдолтой гэх мэт.

Гурав. Гэрээний болон ажил гүйцэтгэх хугацаа, төлбөр

- 3.1 Гэрээ нь 2018 оны 01-р сарын 02-ны өдрөөс 2018 оны 01 сарын 31-ны өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 3.2 Энэхүү гэрээний 3.1-т заасан хугацаа дуусахад гэрээг адил нөхцөлөөр үргэлжлүүлэн сунгах, анх гэрээнд тусгасан үнэ /Гэрээний 2.1/-ийг мөрдлөг болгох эсэхийг талууд тухайн үед нь харилцан тохиролцоно.
- 3.3 Захиалагч нь захиалгат ажлын хөлсийг дараах байдлаар гүйцэтгэгчид төлж барагдуулна:
 - 3.3.1 Захиалгат ажилаа хүлээн авсанаас хойш ажлын 1-3 хоногийн дотор захиалсан ажлын нийт төлбөрийг ажил гүйцэтгэгч талд шилжүүлнэ.
Хаанбанк:5173008245. Голомтбанк:2105101361. ХХБанк:415015885. Төрийн банк:101400226612
 - 3.3.2 Гэрээний хугацаанд удаа дараалан тохирсон хугацаандаа төлбөрөө төлөөгүй үед төлбөрийн нөхцөл өөрчлөх, алданги 0.5% тооцох, гэрээг дуусгавар болгох зэрэг арга хэмжээ авна.
- 3.4 Гүйцэтгэгч нь захиалгат ажлыг гүйцэтгэхдээ энэхүү гэрээний 2.1-д заасан үнийг мөрдлөг болгох ба энэхүү үнийн санал нь сэтгүүлийн үзүүлэлтээс хамаарна. Гэрээний 2.1-д заасан үнийн дүнд НӨАТ болон Улаанбаатар хот доторх тээврийн хөлс багтсан байна.
- 3.5 Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч Гэрээний 2.3-д заасны дагуу ажлыг доголдолтой гүйцэтгэсэн тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр доголдлыг гүйцэтгэгчээр засуулна.

Хуудсыг баталгаажуулсан 1 / 5

- 3.6 Гүйцэтгэгч нь захиалгат ажлыг хэвлэлтэнд шилжүүлэхдээ эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа 1 төрөл ажлыг 15 хоногт багтаан үр дүнг зөрчил, доголдолгүй хийж гүйцэтгэн зарлагын баримтаар хүлээлгэн өгнө.
- 3.7 Нэн яаралтай гэж үзсэн захиалгат ажлын гүйцэтгэх хугацааг Талууд харилцан тохиролцон тогтооно.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1 Захиалагч нь захиалгат ажлын батлагдсан эхийг хэвлэх тоо, хэмжээ, цаасны төрөл, бусад харьцааг Ажил гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.
- 4.2 Захиалагч нь урт хугацааны гэрээны явцад билэн эх бэлтгэлээ өгөхдөө ажлын цагаар буюу 09-17 цагийн хооронд өгч байх.
- 4.3 Захиалагч нь захиалгат ажлын эх загварыг хэвлэлийн эх бэлтгэлийн программ дээр боловсруулж хүлээлгэж өгөх, брэндийн лого, өнгө, стандартууд болон шаардлагатай бусад мэдээллийг Ажил гүйцэтгэгчид өгнө.
- 4.4 Захиалагч ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.
- 4.5 Захиалагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хэвлэлийн процесст хяналт тавих зорилгоор хэвлэлийн үйлдвэрт саадгүй нэвтрэх эрхтэй.
- 4.6 Захиалагч нь захиалгат ажлын хэвлэлийн батлагдсан эхэд зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулсан, тоо хэмжээ дутсан, гэрээнд заасан чанарын шаардлага хангаагүй, биет байдлын болон эрхийн доголдолтой ажлыг гүйцэтгэгчээс хүлээн авахгүй байх эрхтэй.
- 4.7 Захиалагч нь ажил гүйцэтгэгчээс ажлын явцын талаархи мэдээллийг авах, зааварчилгаа өгөх, хяналт тавих, гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 4.8 Захиалагч бэлтгэсэн эх файлаа хэвлэлтэнд оруулахаас өмнө ажил гүйцэтгэгчийн гарган өгсөн пробыг хянаж шалгах үүрэгтэй.
- 4.9 Ажил гүйцэтгэгчийн ажлын үр дүн нь доголдолтой бол ажлын доголдлыг арилгахыг шаардах, доголдлыг арилгах нэмэлт хугацааг тогтоох, нэмэлт хугацаанд доголдлыг арилгуулах эрхтэй.
- 4.10 Гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэхийг ажил гүйцэтгэгчээс шаардах

Тав. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1 Ажил гүйцэтгэгч нь захиалгат ажлыг энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн, ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж биет байдлын болон эрхийн доголдолгүй, гэрээний 2.1-т заасан чанартайгаар тоо ширхэгийн дагуу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэн захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ талаар захиалагчаас тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.2 Ажил гүйцэтгэгч нь Захиалагч өнгөт пробыг шалгаж баталгаажуулан, урьдчилгаа төлбөрийг төлсний дараагаар түүнийг хүлээн авч хэвлэлтийн ажлыг эхлүүлнэ.
- 5.3 Ажил гүйцэтгэгч хэвлэгдэх бүтээгдэхүүний батлагдсан эхийг хүлээн авч, өнгөт проб гаргаж захиалагчаар хянуулах үүрэгтэй.
- 5.4 Ажил гүйцэтгэгч Захиалагчаас өгсөн хэвлэлтийн эхийг өөрчлөх эрхгүй.
- 5.5 Ажил гүйцэтгэгч нь бүтээгдэхүүний эх захиалагчаар хянагдаж, батлагдсаны дараа хэвлэх үүрэгтэй.
- 5.6 Ажил гүйцэтгэгч нь хэвлэлийн эхийг хүлээж авахдаа хэвлэлтийн технологиос шалтгаалан зайлшгүй хийх өөрчлөлтийг Захиалагчтай зөвшилцөн хийнэ.
- 5.7 Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн хүсэлтийн дагуу захиалгат ажлын явц, гүйцэтгэлийн талаархи мэдээллийг өгч ажиллах үүрэгтэй.
- 5.8 Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрсөн тохиолдолд огтлоо, зүсэлт, хэвлэлийн шинэ технологи зэрэг нарийн ажилбар шаардсан захиалгуудыг гуравдагч этгээдэд зуучлан ажил гүйцэтгүүлж болно. Гуравдагч этгээд нь захиалагчийн өгсөн зааврын дагуу ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгээгүйн улмаас гарах хариуцлагыг Ажил гүйцэтгэгч Захиалагчийн өмнө гэрээнд заасны дагуу хүлээнэ.
- 5.9 Ажил гүйцэтгэгч нь Гэрээний хавсралтанд заасан цаасны чанар, сэтгүүлийн хэмжээ, хэвлэлийн технологийг чанд мөрдөж, цаасны хангамжийг бүрэн хариуцан ажиллах үүрэгтэй.
- 5.10 Ажил гүйцэтгэгч нь захиалагчид үзүүлж буй үнийн хөнгөлөлт, төлбөр төлөх нөхцөл болон цаас, хэвлэлийн бүтээгдэхүүн хийхэд шаардагдах түүхий эдийн чанар зэргийг мөрдөн ажиллана.
- 5.11 Гүйцэтгэх ажлын талаар Захиалагчийн өгсөн зааварчилгаа нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхүйц, түүнчлэн ажил гүйцэтгэх хугацаа саатахаар байвал Захиалагчид нэн даруй мэдэгдэх, гүйцэтгэх ажлын бусад хэсэгт ноцтой нөлөөлөхөөр бол гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.

Зургаа. Зохиогчийн эрх

- 6.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад оюуны өмчтэй холбогдсон эрх зүйн (зохиогчийн эрхийг оруулаад) ажиллагааны эрхийг Захиалагч эдлэх ба үүнд ашиглах, хувилах, нийтлэх, орчуулах, худалдах, тараах, хувь хүмүүс, олон нийтэд хүртээх, өөр бусад холбогдсон ажиллагаа орно.

- 6.2 Талууд хамтын ажиллагааны нууцлалыг Гэрээт ажилтан болон түүний хамтран ажиллагчид чанд сахих ба гуравдагч этгээдэд мэдээлэл /тоо ширхэг, эх файлаас текст, зураг авах г.м/ түгээхгүй ба энэхүү ажлын үеэр олж авсан мэдээллийг хувьдаа, эсвэл аливаа байгууллагын эрх ашигт ашиглахгүй байх үүрэгтэй.
- 6.3 Захиалагчийн захиалгат ажлын агуулга болон сэтгүүлд ашиглагдсан материал нь зохиогчийн эрх болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн явдалд Гүйцэтгэгч ямар нэг хариуцлага хүлээхгүй бөгөөд Захиалагч бүрэн хариуцна.
- 6.4 Дээрх заалт гэрээний дагуу ажил хийгдсэн, гэрээний үйл ажиллагааг зогсоосны дараа ч хүчин төгөлдөр байна.

Долоо. Талуудын хүлээх хариуцлага

- 7.1 Талууд бие биенийхээ бизнесийн болон санхүүгийн мэдээ мэдээллийг бусдад задруулах, бизнесийн нэр хүндэд хууль бусаар халдахыг хориглоно.
- 7.2 Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд ажлын хөлсийг төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%-ийн алдангийг Ажил гүйцэтгэгчид төлнө.
- 7.3 Ажил гүйцэтгэгч нь захиалгат ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй, тохирсон тоо ширхэгийг дутаасан тохиолдолд нэмэлт хугацаа тогтоож өгөх ба нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%-ийн алдангийг Захиалагчид төлнө.
- 7.4 Захиалагч тал хэвлэлтийн ажил эхлэхээс өмнө ажлын өнгөт пробыг шалгаж, баталгаажуулаагүйгээс хугацаа хоцорсон болон бусад үүсэх хариуцлагыг хүлээнэ.
- 7.5 Захиалагчийн баталсан эх алдаатайн улмаас үүссэн хохирлыг Гүйцэтгэгч хариуцахгүй.
- 7.6 Талууд энэхүү гэрээний эрх, үүргээ нөгөө талын албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэхийг хориглоно.
- 7.7 Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан тоо ширхэгийн дагуу ажлыг захиалагчид хүлээлгэн өгөх бөгөөд нийт захиалгат ажлын тооноос 10%-с дээш дутсан тохиолдолд тухайн захиалгат ажлыг 3 хоногийн дотор багтаан хэвлэн гүйцээн өгөх ба 10%-с доош тохиолдолд үнийн дүнгээс дутсан хэмжээгээр хасалт хийж тооцно. Ажил гүйцэтгэгч нь заасан хугацаанд тухайн захиалгат ажлыг гүйцээн хэвлэх тохиолдолд гэрээний 7.3-д заасан хариуцлагыг хүлээнэ.
- 7.8 Захиалгат ажил бүрийн гомдлын шаардлага тавих хугацаа нь ажлыг бүрэн хүлээж авснаас хойш хуанлийн 14 /арван дөрвөн / хоног байна.
- 7.9 Учирсан хохирол гэдэгт Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас аль нэг талд гуравдагч этгээдээс гаргасан гомдлын шаардлагыг хангахтай холбоотой зардал, өөрт учирсан бодит хохирлыг ойлгоно.
- 7.10 Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд шаардлагатай мэдээлэл өгөөгүй, загварыг баталгаажуулаагүй тохиолдолд тэр хэмжээгээр Ажил гүйцэтгэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.
- 7.11 Алданги торгууль төлсөн нь Талуудыг үндсэн үүрэг болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 7.12 Талуудын аль нэгний буруутай үйлдлээс нөгөө талд хохирол учруулсан, нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн төлж барагдуулна.

Найм. Гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлах үндэслэл

- 8.1 Энэхүү гэрээ нь талууд гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлснээр эсхүл гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар, гэрээний хугацаа дууссанаар дуусгавар болно.
- 8.2 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлах бол талууд бие биедээ ажлын 5 хоногийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэнэ.
- 8.3 Гэрээг дараах тохиолдолд цуцална.
- 8.4 Гүйцэтгэгч доголдолтой ажил нийлүүлсэн эсхүл гэрээнд заасан нэмэлт хугацаанд ажлын доголдлыг арилгаагүй, удаа дараалан зөрчил заргасан, /доголдолыг талууд акт баримтаар тогтоох буюу шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн хөндлөнгийн экспертизээр тогтоолгох/
- 8.5 Захиалагч ажлын хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй,

Ес. Бусад зүйл

- 9.1 Талууд нэгэндээ ямар ч мэдэгдэл, шаардлага, хүсэлтийг бичгээр хийж өгөх бөгөөд доорх хаягаар хаяглана. Хаягийн өөрчлөлтийг Талууд нөгөө талдаа мэдэгдэх үүргийг хүлээнэ.
- 9.2 Гэрээг хоёр эх хувь үйлдэн талууд тус бүрийг хадгална. Хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчин чадалтай.
- 9.3 Ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэх, захиалгын хуудас, захиалгат ажил хүлээлцсэн акт зэргийг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 9.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэх бөгөөд санал авсан тал ажлын 3 хоногийн дотор саналаа нөгөө талдаа мэдэгдэн асуудлыг шийдвэрлэнэ. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон тохиолдолд талууд бичгээр үйлдэн, тамга тэмдгээр баталгаажуулан оруулна.

- 9.5 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 9.6 Ажлын үр дүн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр устсан гэмтсэнээс үүсэх хариуцлагыг хүлээлгэн өгөхөөс өмнө Гүйцэтгэгч, хүлээн авснаас хойш Захиалагч хариуцна.
- 9.7 Гэрээтэй холбогдон гарах аливаа асуудлыг талууд зөвшилцөлийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Борлуулалтын ахлах менежер
С.Амарбаяр



Борлуулалтын менежер
Э.Бадмаараг



№АУ-...../..... дугаартай гэрээний хавсралт

№	Захиалгат ажлын нэр	Цэвэр хэмжээ	Цаас		Нууцлал
			Цаасны төрөл	Цаасны жин	
1	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	A4	Нууцлалтай цаас	180гр	Тусгай зориулалттай Канад улсын үнэт цаас үйлдвэрлэлийн Ролланд Интерпрайсес компанийн Усан хээтэй ялтсан нууцлал бүхий 180гр-н үнэт цаасаар Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний техникийн тодорхойлолтын дагуу зориулалтын орчинд хэвлэнэ.
Үнэ, тоо хэмжээ					
	Хэвлэлийн нэр	Хэвлэх тоо		Нэгж үнэ	Нийт үнэ /төгрөг/
1	Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаас	200		30,000	6,000,000

Хавсралт баталгаажуулсан:

ГҮЙЦЭГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Борлуулалтын ахлах менежер
С.Амарбаяр



Борлуулалтын менежер
Э.Бадмаараг

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
НБББГ-н дарга
Г.Түвдэндорж



ТЗУГ –н Санхүүгийн хэлтсийн дарга
С.Мөнгөнцэцэг